



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.09.23 № 03/1861

танай _____-ны № _____-г

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх НХААГ/20240101548 дугаартай "Алтан овооны замын уулзвараас Найрамдалын зам хүртэлх авто зам"-ын ажлын магадлал хийгдсэн зураг, төсвийг захиалагчийн хяналт тавих байгууллагаас ирүүлсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтын дагуу тендерийн шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

№	Тендер шалгаруулалтын баримт бичгийн заалт	Орсон өөрчлөлт
1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.1 дэх заалт: Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр, Цаг: 09 цаг 00 минут гэснийг;	Тендерийн хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Цаг: 09 цаг 00 минут гэж;
2	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.2 дахь заалт: Тендер нээлт хийх хугацаа нь: 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр, Цаг: 09 цаг 30 минут гэснийг;	Тендер нээлт хийх хугацаа нь: 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Цаг: 09 цаг 30 минут гэж;
3	Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөл ирүүлнэ. Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгодог: <ul style="list-style-type: none">2.8.2.1.1 5 км хүртэл хатуу хучилттай зам барих болон түүнээс дээш, эсхүл5.2.3.1 Авто зам барих-Бүх төрлийн асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсэн хучилттай авто замыг барих (Их засвар, шинэчлэлт) гэснийг;	Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөл ирүүлнэ. Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгодог: <ul style="list-style-type: none">2.8.2.1.1 5 км хүртэл хатуу хучилттай зам барих болон түүнээс дээш, эсхүл5.2.3.1 Авто зам барих-Бүх төрлийн асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсэн хучилттай авто замыг барих (Их засвар, шинэчлэлт) Эрчим хүчний яамнаас олгодог ТЗ-2.3 0.4-110кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх гэж;

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно. Ажлын зураг төсвийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн “ТЭЗҮ” хэсгээс харна уу.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
Удирдлага
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Даваадорж Батцэцэг
2024.09.23 14:53